

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 13 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 13 дугаар хуралдааныг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 14 цаг 00 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Төрийн хэмнэлтийн хууль болон Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн танилцуулга хэлэлцүүлэх тухай	<p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аймгийн төв, сумдад татан төвлөрүүлэх, худалдан борлуулах, үүрэг гүйцэтгэх машины тоо болон автобус, машины хэрэгцээг нэг ээлжиндээ хэдэн удаа явах тооцоо гаргаж, хэдэн машин авч үлдэх судалгаа гаргах;</li> <li>2. “Авто үйлчилгээний алба” гэдэг нэр өгөх;</li> <li>3. Машин дуудлагын авто баазыг Засаг даргын Тамгын газарт ойрхон байгуулах;</li> <li>4. Сумдын машиныг сумдад татан төвлөрүүлэх, авто баазыг сумдад нь байгуулах;</li> <li>5. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 5 авто машин үлдэх, Музейн авто машиныг дуудлага худалдаан оруулах, Номын сангийн машиныг татан төвлөрүүлэх, Сум дундын ойн ангийн машиныг татан төвлөрүүлэх, Боловсрол, шинжлэх ухааны газрын машиныг зарах;</li> <li>6. Зэрэг, Цэцэг сумдын Засаг даргын Тамгын газрын авто машиныг хэрхэх талаар саналыг авах, Дарви сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, Мөнххайрхан сумын сургууль, Соёлын төв машиныг тус тус татан төвлөрүүлэх;</li> <li>7. Мөнххайрхан сумын сургууль, Чандмань сумын Соёлын төвийн машиныг тус тус дуудлага худалдаанд оруулах.</li> <li>8. Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон тус сумын приус, Мөст сумын сургуулийн пургон, Дуут сумын Өрхийн эрүүл мэндийн төв машин, Жаргалан Өрхийн эрүүл мэндийн төв, Үенч сумын пургон машиныг тус тус баазад бүртгэж үлдээх, Үенч сумын истана машин, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын машиныг татан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт тус тус үүрэг болгов.</li> </ol>
2	Чандмань сумын нутаг дэвсгэрт зохион байгуулах “Баруун бүсийн даншиг наадам”-ын бэлтгэл хангах талаар танилцуулга	<p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Хан Жаргалантын хурд-2022” Баруун бүсийн Бат-Оршил даншиг наадмын зохион байгуулалттай холбоотой бэлтгэл ажлын талаар ярилцаж холбогдох байгууллагуудын дарга нарт үүрэг чиглэл өгч, бэлтгэл ажлыг сайтар хангуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ажлын хэсгийн ахлагч Д.Энхболдод үүрэг болгов.</li> <li>2. Наадмын нээлт, хаалтын үзүүлбэрийг Хөгжим</li> </ol>

		<p>драмын театрын уран бүтээлчид хариуцан ажиллахыг С.Ариунжаргалд үүрэг болгов.</p> <p>3. Цахилгааны асуудлыг хариуцан ажиллахыг Цахилгаан түгээх сүлжээний дарга С.Гантөмөрт үүрэг болгов.</p> <p>4. Морины бариа цэгцлэх, морьд бүртгэх ажлыг Мал эмнэлгийн газрын дарга Д.Батцэнгэлд үүрэг болгов.</p> <p>5. Морины бариа, гэр гуанз, бусад зочдын 00 асуудал, хогийн функер байрлуулах ажлыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Л.Батбаярт хариуцуулав.</p> <p>6. Морины олс, хайлс, харуул хамгаалалтад ажиллах хүн хүчний ажлыг Цагдаагийн газрын дарга Д.Мөнхболдод хариуцуулав.</p> <p>7. “Хан Жаргалантын хурд-2022” Баруун бүсийн Бат-Оршил даншиг наадмыг зохион байгуулахтай холбоотой Дарви, Манхан, Дөргөн, Цэцэг сумын Засаг дарга нар луу зочид төлөөлөгчид хүлээн авч үйлчлэх 3 гэр, үйлчлэгчийн хамт, мөн Ховд их сургууль руу 50 ор хүссэн албан бичиг явуулахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.</p>
--	--	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР